



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №37


2018 оны 10-р сарын 22-26

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1237** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 110(8.9%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1091(88.3%) хачигт халдвар, 19(1.5%) бэтэг, 2(0.2%) хумхаа, 8(0.7%) боом, 6(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1091** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14%-иар бага байна.



Хачигт риккетсиозын 811 сэжигтэй тохиолдлын 199(24.5%), хачигт энцефалитын 185 сэжигтэй тохиолдлын 32(17.3%), хачигт боррелиозын 95 сэжигтэй тохиолдлын 24(25.3%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдсан байна

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **110** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.5%-иар буурсан, эпидемиологийн 42-р долоо хоногоос 1 сэжигтэй тохиолдлоор бага байна.




1.3 Боомын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

10 дугаар сарын 23-ны өдөр УКНТЭ-ээс боомын хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдэж, ЗӨСҮТ-ээс мэргэжлийн баг үзлэг хийж, оношийг тархвар судлал, эмнэлзүйгээр үгүйсгэж, лавлагаа лабораторид сорьц дээжилж лабораторид хийгдсэн молекул биологийн шинжилгээгээр боомын нянгийн ДНХ илрээгүй тул онош үгүйсгэгдсэн байна.

1.4 Мэрэгч амьтны дуудлага:

Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ээс мэрэгч амьтны нийт 91 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс 16.1%-иар их байна. Эпидемиологийн 42-р долоо хоногтой харьцуулахад 3 тохиолдлоор бага байна.



Энэ 7 хоногт Нийслэлийн БГД, СХД дүүргийн хэмжээнд 2 удаагийн амьтны дуудлаганд үйлчилсэн. Хураагдсан сорьц материалд ЗӨСҮТ-ийн лабораторид шинжилгээ хийгдэж байна

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны өвчин:

Баян-Өлгий аймгийн Толбо сум, Бураат багийн “Бураатын даваа” гэдэг газар тус сумын харьяат малчин “Ж”-ын 50 хонь, 8 ямаа, нийт 67 толгой мал 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдөр шалтгаан тодорхойгүй хорогдож, сумын Засаг даргын орлогч болон аймгийн малын их эмчээр ахлуулсан ажлын хэсэг тухайн газар тандалт хийсэн байна.

Хариу арга хэмжээ:

- 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр УМЭАЦТЛ-д хорогдсон малаас сорьц, дээж авч илгээсэн.
- Нэмэгдэж өвчилсөн мал байхгүй, үхсэн малын сэг зэмийг устгах ажиллагаа явагдаж лабораторийн шинжилгээ үргэлжилж байна.

Эх сурвалж: ОБЕГ

Мал, амьтны галзуу өвчин:

2018 оны 10-р сарын 18 наас 10-р сарын 25-ны хугацаанд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Хэрлэн сумдын нутагт эзэнтэй нохойд нийт 4 хүн уруулж ноцуулсан дүнтэй байна.

Хариу арга хэмжээ:

- Нохойг уяж 14 хоног ажиглаж, уруулж ноцуулсан 4 тохиодолуудыг дархлаажуулалтад хамруулсан байна.
- ЗӨСТөвийн эмч, мэргэжилтэнүүд Хэрлэн сумын 2-р багийн 474 айл өрхүүдэд галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, санамж сэрэмжлүүлэг тараан, сургалт сурталчилгаа зохион байгуулан ажиллаж байна.

Эх сурвалж: Хэнтий аймаг ЗӨСТ

Олон улсад:

Шүлхий өвчин:

БНХАУ улсын Өвөр Монголын өөртөө засах орны Хөлөнбуйр хотын Баянтохой гэх газар үхрийн аж ахуйд “0” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин улмаас 140 үхэр өртөж, 17 үхэр өвчилсөн байна. Тус газар хязгаарлалтын дэглэм тогтоон ажиллажээ.




Зураг 1.БНХАУ, Шүлхийн тархалт

Эх сурвалж: ДАЭМБ

Эбола вируст халдвар:

Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад 10 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар Хойд Киву мужийн (Mabalako, Beni, Kalunguta, Masereka, Butembo, Oicha, Musienene), Итури мужийн (Mandima) эрүүл мэндийн төвөөс эбола вируст халдварын нийт 237 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, 35 тохиолдол батлагдсан байна. Нас баралтын түвшин 64.5%(153) тай байна.



Зураг 2.БНАК, ЭВХ-ын тархалт

Эх сурвалж: ДЭМБ

Африкийн гахайн халуурал өвчин:

Япон улсын хөдөө аж ахуйн яамны мэдээлснээр Хоккайдо арлын нисэх онгоцны буудал дээр БНХАУ-аас ирсэн зорчигчийн тээшинд хийсэн шалгалтаар Африкийн гахайн халуурал өвчний үүсгэгч илэрсэн байна. Тус улсад хөдөө аж ахуйн яамнаас дотоод хяналт шинжилгээ, бэлэн байдлыг хангаж ажиллах талаар уриалсан байна.



Зураг 3. Африкийн гахайн халуурал өвчин бүртгэгдсэн тохиолдлын байршил (Япон улс)
Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин:

Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Хөдөө аж ахуйн яамны мэдээлсэнээр 2018 оны 10 дугаар сарын 23-ны байдлаар тус улсын (Kandonmai, Thateng, Sekong) зэрэг мужид шувууны томуугийн А хүрээний H5N1 вируст халдвараар 28 шувуу өвчилж, 27 шувууг устгасан байна.



Зураг 4. Шувууны томуугийн А хүрээний H5N1 вируст халдвар (БНАЛАУ)
Эх сурвалж: ДАЭМБ